



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/Анч

Булган сум

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын  
сургуулийн лингафон танхим хүлээж авах  
ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, ханах тайлагнах журам”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэн ажиллах “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуульд лингафон танхимыг байгуулах, тохижуулах, тоног төхөөрөмж, техникийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: 3.Батбагана (Аймгийн Засаг даргын тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)  
Гишүүд: Л.Одгэрэл (Боловсролын газрын Гадаад хэлний  
боловсрол хариуцсан ахлах арга зүйч)  
Б.Эрдэнэтуяа (Гурванбулаг сумын Засаг даргын тамгын  
газрын дарга)  
А.Туулсайхан (Гурванбулаг сумын Ерөнхий  
боловсролын сургуулийн Англи хэлний багш, “Англи  
хэлтэй Булган” дэд хөтөлбөрийн нарийн бичиг)  
Нарийн бичгийн дарга: Н.Хүрэлсүх (Боловсролын газрын Хөрөнгө оруулалт,  
төсвийн гүйцэтгэл хариуцсан ахлах арга зүйч)

2.Лингафон танхимыг байгуулах ажлын гүйцэтгэлийг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, актыг үйлдэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (3.Батбагана)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР